



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 5/27

Ховд


У.Цэрэнтогтохыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, Улсын Их Хурлын 2007 оны 73 дугаар “Улс төрийн албан хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэх тогтоох тухай” тогтоолын 1 дэх заалтууд, Эрдэнэбүрэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 1/30 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар 100 хувийн санал авсан Уртнасангийн Цэрэнтогтохыг 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн Эрдэнэбүрэн сумын Засаг даргаар томилсугай.

2. У.Цэрэнтогтоход Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын “Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох” 11 дүгээр хавсралтын дагуу 1052207 төгрөг /Нэг сая тавин хоёр мянга хоёр зуун долоон/-өөр цалинжуулж, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийн хэмжээг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар тооцон сар бүр олгохыг Эрдэнэбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Б.Баяндалай/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ